

АУДИТ, БАТАЛГААЖУУЛАЛТ, БИЗНЕСИЙН ЗӨВЛӨХ  
ҮЙЛЧИЛГЭЭ, АУТСОРСИНГ, СУРГАЛТ

## БИЗКОН АУДИТ ХХК

67123 Мөрөн сум, Хөвсгөл аймаг

Утас: 7011-9107 E-mail: info@bizcon.mn

*Хөвсгөл. А. 24* № *06*

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### ХӨВСГӨЛ АЙМГИЙН ХАТГАЛ ТОСГОНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВД

Танай байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж гүйцэтгэн аудитын тайланг хүргүүлж байна.

Хамтран ажилласан та бүхэнд талархлаа илэрхийлэе.

ЗАХИРАЛ



Ч.МӨНХБАЯР



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsqul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2022.09.21 № 01/202  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ХАТГАЛ  
ТОСГОНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ТӨВИЙН ДАРГА П.ЦЭРЭНДОЛГОР  
ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Хатгал тосгоны Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйцгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Хатгал тосгоны Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Хатгал тосгоны Эрүүл Мэндийн Төвийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2022/125/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Хөвсгөл аймаг  
Мөрөн сум  
2022 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар  
Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatar@audit.gov.mn](mailto:erdenebaatar@audit.gov.mn)  
Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ  
Утас: 88090438 Цахим хаяг: [baterdenee@audit.gov.mn](mailto:baterdenee@audit.gov.mn)  
Ахлах аудитор: Л.Отгонбаяр  
Цахим хаяг: [lmfo@bizcon.mn](mailto:lmfo@bizcon.mn)  
Ахлах аудитор Ч.Мөнхбаяр  
Утас: 99996784 Цахим хаяг: [mm.bayar0711@gmail.com](mailto:mm.bayar0711@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ХӨА	Хөвсгөл аймаг
НА	Нотлох аудит
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ҮОМШӨ	Үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах өвчин
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн Хурал

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>104,673,931.92</b>	<b>208,127,733.00</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	00.00	1,466,460.00
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	00.00	1,466,460.00
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	00.00	1,466,460.00
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	00.00	1,466,460.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	00.00	41,290,841.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	1,054,806.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	00.00	36,781,300.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	00.00	3,454,735.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	3,454,735.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	104,673,931.92	165,370,432.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	14,669,485.58	25,693,179.39
35110	Тусгай зориулалттай материал	8,503,468.54	00.00
35130	Эм боох материал	6,166,017.04	25,693,179.39
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	65,784,446.34	118,917,252.61
35410	Бичиг хэргийн материал	1,027,795.00	4,240,188.00
35420	Аж ахуйн материал	41,621,417.18	80,628,284.65
35430	Сэлбэг хэрэгсэл	00.00	1,478,400.00
35440	Түлш, шатах тослох материал	904,398.60	2,215,714.00
35460	Хүнсний материал	3,279,935.54	6,306,496.04
35470	Бусад хангамжийн материал	18,950,900.02	24,048,169.92
35600	Мал амьтад	24,220,000.00	20,760,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>408,197,836.07</b>	<b>472,531,576.17</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	408,197,836.07	472,531,576.17
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	370,899,752.64	449,331,492.70
39201	Барилга, байгууламж, орон сууц	206,790,426.71	206,790,426.71
39202	Хуримтлагдсан элэгдэл	-38,711,942.56	-58,155,413.80
39203	Авто-тээврийн хэрэгсэл	31,946,434.00	31,946,434.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-17,640,919.90	-23,038,992.22
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	269,150,894.50	337,488,819.01
39206	Хуримтлагдсан элэгдэл	-96,030,321.41	-75,543,355.59
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	16,417,528.00	28,384,500.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-9,337,861.44	-5,496,006.03
39214	Бусад үндсэн хөрөнгө	11,036,382.98	11,036,382.98
39215	Хуримтлагдсан элэгдэл	-2,720,868.24	-4,081,302.36
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	37,298,083.43	23,200,083.47
39301	Программ хангамж	16,000,000.00	1,265,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-857,916.57	-220,916.53
39303	Бусад биет бус хөрөнгө	22,156,000.00	22,156,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>512,871,767.99</b>	<b>680,659,309.17</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>512,871,767.99</b>	<b>680,659,309.17</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	512,871,767.99	680,659,309.17
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	380,890,939.00	380,890,939.00
51101	Өмч: - төрийн	380,890,939.00	380,890,939.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	14,594,223.73	189,401,764.91
51210	Өмнөх үеийн үр дүн	14,594,223.73	21,614,223.73
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	167,787,541.18

51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	117,386,605.26	110,366,605.26
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>512,871,767.99</b>	<b>680,659,309.17</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>688,651,231.97</b>	<b>1,200,696,436.28</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>175,086,021.97</b>	<b>387,289,656.28</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	175,086,021.97	387,289,656.28
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	175,086,021.97	387,289,656.28
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	175,086,021.97	387,289,656.28
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>513,565,210.00</b>	<b>813,406,780.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	451,883,100.00	541,418,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	451,883,100.00	00.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	00.00	541,418,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	18,350,700.00	201,718,980.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	315,900.00	1,241,300.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	494,800.00	32,423,480.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	17,540,000.00	2,984,200.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого	00.00	165,070,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	00.00	-29,319,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	29,319,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	43,331,410.00	40,950,800.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	43,331,410.00	40,950,800.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>544,783,697.00</b>	<b>1,017,908,895.10</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>544,783,697.00</b>	<b>1,017,908,895.10</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	544,303,697.00	986,908,895.10
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	330,741,839.00	475,840,860.00
210101	Үндсэн цалин	198,453,300.00	250,671,688.00
210102	Нэмэгдэл	97,093,639.00	148,536,500.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,427,000.00	10,145,868.00
210104	Урамшуулал	29,767,900.00	37,697,804.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	28,789,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	44,676,000.00	60,817,434.00
210201	Тэтгэврийн даатгал	31,666,600.00	44,787,434.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,252,300.00	4,007,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,601,900.00	3,206,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	650,500.00	801,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,504,700.00	8,015,000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	12,193,300.00	20,371,730.10
210301	Гэрэл, цахилгаан	2,507,300.00	4,075,300.00
210302	Түлш, халаалт	9,229,000.00	15,726,430.10
210303	Цэвэр, бохир ус	457,000.00	570,000.00

Хөвсгөл аймгийн Хатгал тосгоны Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	7,020,000.00	7,020,000.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>380,890,939.00</b>	<b>117,386,605.26</b>	<b>21,614,223.73</b>	519,891,767.99
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-7,020,000.00	00.00	-7,020,000.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	167,787,541.18	167,787,541.18
D09	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>380,890,939.00</b>	<b>110,366,605.26</b>	<b>189,401,764.91</b>	680,659,309.17

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөгөөр/**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>513,565,210.00</b>	<b>776,625,480.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>513,565,210.00</b>	<b>776,625,480.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	451,883,100.00	541,418,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	451,883,100.00	00.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	00.00	541,418,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	18,350,700.00	164,937,680.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	315,900.00	1,241,300.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	494,800.00	32,423,480.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	17,540,000.00	2,984,200.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого	00.00	128,288,700.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	00.00	29,319,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	29,319,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	43,331,410.00	40,950,800.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	43,331,410.00	40,950,800.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>496,683,410.00</b>	<b>739,522,020.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>496,683,410.00</b>	<b>739,522,020.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>496,203,410.00</b>	<b>708,522,020.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	330,741,839.00	475,840,860.00
210101	Үндсэн цалин	198,453,300.00	250,671,688.00
210102	Нэмэгдэл	97,093,639.00	148,536,500.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,427,000.00	10,145,868.00
210104	Урамшуулал	29,767,900.00	37,697,804.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	28,789,000.00

Хөвсгөл аймгийн Хатгал тосгоны Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	44,676,000.00	61,872,240.00
210201	Тэтгэврийн даатгал	31,666,600.00	45,842,240.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,252,300.00	4,007,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,601,900.00	3,206,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	650,500.00	801,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,504,700.00	8,015,000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	20,477,000.00	25,469,000.00
210301	Гэрэл, цахилгаан	2,507,300.00	4,075,300.00
210302	Түлш, халаалт	17,473,700.00	20,823,700.00
210303	Цэвэр, бохир ус	496,000.00	570,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	20,901,296.00	39,206,680.00
210401	Бичиг хэрэг	1,048,500.00	2,750,000.00
210402	Тээвэр, шатахуун	11,077,900.00	18,855,480.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	510,000.00	3,940,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	465,500.00	1,477,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,799,396.00	12,183,400.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	34,397,773.00	72,740,416.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	25,399,969.00	54,202,700.00
210502	Хоол, хүнс	7,897,804.00	16,537,716.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,100,000.00	2,000,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	8,565,540.00	7,863,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,830,000.00	00.00
210602	Тавилга	00.00	363,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,385,540.00	2,000,000.00
210604	Урсгал засвар	3,350,000.00	5,500,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	890,800.00	456,000.00
210702	Дотоод албан томилолт	890,800.00	456,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	30,553,162.00	18,611,724.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	26,791,544.00	15,453,024.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	320,000.00	500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	108,900.00	195,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	57,510.00	57,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,506,800.00	00.00
210807	Газрын төлбөр	44,308.00	44,400.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	680,100.00	2,328,700.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	5,000,000.00	6,462,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	6,462,100.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>480,000.00</b>	<b>31,000,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>480,000.00</b>	<b>31,000,000.00</b>

Хөвсгөл аймгийн Хатгал тосгоны Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	31,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	480,000.00	00.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>16,881,800.00</b>	<b>37,103,460.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>16,881,800.00</b>	<b>35,637,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>16,881,800.00</b>	<b>35,637,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	16,881,800.00	35,637,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	16,881,800.00	35,637,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>-16,881,800.00</b>	<b>-35,637,000.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	00.00	1,466,460.00
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	00.00
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	1,466,460.00

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	612,445,700.00	611,687,800.00
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	612,445,700.00	611,687,800.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	612,445,700.00	611,687,800.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	400,748,800.00	400,748,800.00
210101	Үндсэн цалин	226,530,000.00	226,530,000.00
210102	Нэмэгдэл	108,413,000.00	108,413,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,056,000.00	7,056,000.00
210104	Урамшуулал	29,960,800.00	29,960,800.00
210105	Гэрээт ажлын хөлс	28,789,000.00	28,789,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	54,101,100.00	54,101,100.00
210201	Тэтгэврийн даатгал	38,071,100.00	38,071,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,007,500.00	4,007,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,206,000.00	3,206,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	801,500.00	801,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,015,000.00	8,015,000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	25,319,000.00	25,319,000.00
210301	Гэрэл, цахилгаан	4,525,300.00	4,075,300.00
210302	Түлш, халаалт	20,373,700.00	20,823,700.00
210303	Цэвэр, бохир ус	420,000.00	420,000.00
210304	Байрны түрээс	00.00	00.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	30,742,800.00	30,742,800.00
210401	Бичиг хэрэг	2,250,000.00	2,250,000.00
210402	Тээвэр, шатахуун	16,685,000.00	16,685,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,830,000.00	3,830,000.00
210404	Ном, хэвлэл	00.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,477,800.00	1,477,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,500,000.00	6,500,000.00

Хөвсгөл аймгийн Хатгал тосгоны Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	48,793,000.00	48,793,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	37,000,000.00	37,000,000.00
210502	Хоол, хүнс	9,793,000.00	9,793,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,000,000.00	2,000,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	43,500,000.00	43,500,000.00
210602	Тавилга	36,000,000.00	36,000,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,000,000.00	2,000,000.00
210604	Урсгал засвар	5,500,000.00	5,500,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	700,000.00	168,000.00
210702	Дотоод албан томилолт	700,000.00	168,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,541,000.00	2,530,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	800,000.00	800,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	195,000.00	195,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	57,600.00	57,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	33,000.00
210807	Газрын төлбөр	44,400.00	44,400.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	900,000.00	900,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	6,000,000.00	5,785,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,000,000.00	5,785,100.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	612,445,700.00	611,687,800.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	541,418,000.00	541,418,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	541,418,000.00	541,418,000.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	29,319,000.00	29,319,000.00
132001	Орон нутгийн төсвөөс	29,319,000.00	29,319,000.00
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	41,708,700.00	40,950,800.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	41,708,700.00	40,950,800.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	24	24
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	14	14
620003	Үйлчлэх ажилтан	9	9

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>163,471,220.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>163,471,220.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	132,471,220.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	75,092,060.00
210101	Үндсэн цалин	24,141,688.00
210102	Нэмэгдэл	40,123,500.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,089,868.00
210104	Урамшуулал	7,737,004.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	7,771,140.00
210201	Тэтгэврийн даатгал	7,771,140.00

Хөвсгөл аймгийн Хатгал тосгоны Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	150,000.00
210303	Цэвэр, бохир ус	150,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	8,463,880.00
210401	Бичиг хэрэг	500,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,170,480.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	110,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,683,400.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	23,947,416.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	17,202,700.00
210502	Хоол, хүнс	6,744,716.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	288,000.00
210702	Дотоод албан томилолт	288,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	16,081,724.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,653,024.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,428,700.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	677,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	677,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	31000000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	31,000,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	31,000,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>164,937,680.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>164,937,680.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,241,300.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	32,423,480.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,984,200.00
131107	Төсвийн урамшуулал	128,288,700.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,466,460.00

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Хатгал тосгоны Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Бизкон Аудит ХХК-ийн Хөвсгөл салбарын ахлах аудитор Л.Отгонбаяр, аудитор Ч.Мөнхбаяр нар гүйцэтгэж, хяналтыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Эрдэнэчимэг, аудитын менежер Э.Бат-Эрдэнэ, газрын дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөвсгөл аймгийн Хатгал тосгоны Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Бизкон Аудит ХХК-ийн Хөвсгөл салбарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Хөвсгөл аймгийн Хатгал тосгоны Эрүүл мэндийн төв нь Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 1 дүгээр зүйлд зааснаар “Эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, үндсэн зарчмыг тодорхойлж, иргэний эрүүл мэндээ хамгаалуулах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах эрхийг хангахад аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, иргэний гүйцэтгэх үүрэг, эрүүл мэндийн байгууллага, ажилтны үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэж байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Тус төв нь Эрүүл мэндийн яамны салбар байгууллага бөгөөд 2021 оноос эхлэн аймгийн ТЭЗ-ийн харьяа байгууллага /төсөв, санхүүгийн тухайд/ болсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд: Засгийн Газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”-ыг хэрэгжүүлэх, “Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн хүснэгтийн Тэтгэврийн даатгал-Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний “9.5” гэснийг “8.5” гэж, Тэтгэврийн даатгал-Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний “9.5” гэснийг “8.5” гэж, Шимтгэлийн дүн-Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний “12.7” гэснийг “11.7” гэж, Шимтгэлийн дүн-Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний “12.5” гэснийг “11.5” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “12.5 хувиас” гэснийг “11.5 хувиас” гэж тус тус өөрчилсүгэй” гэж заасныг хэрэгжүүлж ажилласан байна.

Мөн Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг шинэчлэн баталсныг мөрдөн ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллага нь 2020 онд улсын төсвийн байгууллага байсан бөгөөд 2021 оны санхүүгийн жилд орон нутгийн төсвийн байгууллага болсон байна. Орон нутгийн төсөвт байгууллага

болсноор Хөвсгөл аймгийн Засаг даргын 2019 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн А/375 дугаар захирамжаар баталсан НБББББ-ийг мөрдөн ажиллаж байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Хатгал тосгоны Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 544.8 сая төгрөгөөс 2 хувиар буюу 10.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 8.7 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хөвсгөл аймгийн Хатгал тосгоны Эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 167.9 сая төгрөгөөр буюу 33 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө 1.5 сая төгрөгөөр, авлага 41.3 сая төгрөгөөр өссөн байна. Бараа материал 60.7 сая төгрөг, үндсэн хөрөнгө 64.3 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	1.5	1.5
Авлага	0.0	41.3	41.3
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	104.6	165.4	60.7
Үндсэн хөрөнгө	408.2	472.5	64.3
<b>Нийт хөрөнгө</b>	<b>512.8</b>	<b>680.7</b>	<b>167.8</b>
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	512.8	680.7	167.8
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>512.8</b>	<b>680.7</b>	<b>167.8</b>

Тайлант онд 1.5 сая төгрөгийн мөнгөн хөрөнгө, 41.3 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 165.4 сая төгрөг болж 60.7 сая төгрөгөөр өссөн нь Эрүүл мэндийн газраас 31.7 сая төгрөгийн ковид-19 цар тахлын хувцас нэг удаагийн хэрэгсэл, 224.4 сая төгрөгийн вакцин био бэлдмэл, бусад байгууллагаас 4.7 сая төгрөгийн нэг удаагийн хувцас хэрэгсэл хүлээн авсан, төсвийн хөрөнгөөр 137.0 сая төгрөгийн бараа материал худалдан авснаас шалтгаалжээ. Бараа материалын данснаас тайлант онд 4.4 сая төгрөгийн бараа материал акталсан, 341.0 сая төгрөгийн бараа материал зарцуулсан байна.

Энэ нь бараа материалын нөөц их хэмжээгээр үүсгэсэн мэт харагдах боловч ковид -19 цар тахлын нэг удаагийн хэрэгслийн 7 хоногийн нөөц бэлдсэн. /Мэргэжлийн хяналтын газраас 1 сарын нөөц үүсгэх зөвлөмж өгсөн./

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 472.5 сая төгрөг болж 64.3 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 35.6 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан, ЭМЯ-аас 52.2 сая төгрөг шүдний тоног төхөөрөмж, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 27.6 сая төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж, гадаадын зээл тусламжаар 5.1 сая төгрөгийн эмнэлгийн багаж хэрэгсэл, монпен төслөөс 2.7 сая төгрөгийн эмнэлгийн хэрэгсэл нийт 87.6 сая төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авч үндсэн хөрөнгө дансанд бүртгэсэн зэрэг нь шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө данснаас 1.9 сая төгрөгийн бараа материал шилжүүлсэн, 31.1 сая төгрөгийн хөрөнгө акталж устгасан байна.

15.0 сая төгрөгийн анхны өртөгтэй цахим программ акталж, санхүүгийн болон цалингийн программыг дахин үнэлсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 380.9 сая төгрөг байна.

Тус байгууллагын 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос өмнөх оноос 512.0 сая төгрөгөөр буюу 74 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үзүүлэлт нь үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө материал 387.3 сая төгрөг, урсгал үйл ажиллагааны санхүүжилт 611.6 сая төгрөг, нэмэлт санхүүжилтийн орлого 164.9 сая төгрөг тус тус хүлээн авсан байна.

Нийт зардал өмнөх оноос 473.1 сая төгрөгөөр буюу 87 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, хөлс, болон нэмэгдэл урамшуулал, эм бэлдмэл, хоол хүнсний зардлууд өссөн байна. Энэ нь ковид-19 цар тахал өвчнөөс шалтгаалсан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан 7.0 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн залруулгад бичилт хийсэн байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Хөвсгөл аймгийн Хатгал тосгоны Эрүүл мэндийн төвийн 2021 оны төсвийн төслийг 617.5 сая төгрөгөөр, нийт зарлагыг 617.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 5.1 сая төгрөгөөр бууруулж 612.4 сая төгрөгөөр баталсан байна. Үүнд: 541.4 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 41.7 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 29.3 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Хөвсгөл аймгийн Хатгал тосгоны Эрүүл мэндийн төв нь 2021 онд 541.4 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 40.9 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 29.3 сая

төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 611.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжаар 1.2 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 32.4 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 2.9 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 128.3 сая төгрөг нийт 164.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс: цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардалд 75.1 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 0.1 сая төгрөг, хангамж бараа материалын зардалд 8.5 сая төгрөг, норматив зардалд 23.9 сая төгрөг, албан томилолтын зардалд 0.3 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ зардалд 16.1 сая төгрөг, бараа үйлчилгээний зардал 0.7 сая төгрөг, бусад урсгал шилжүүлэг 31.0 сая төгрөг нийт 163.4 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 1.5 сая төгрөг байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайланд тусгагдаагүй онцлог үйл ажиллагааг харуулбал. Үүнд:

Ковид 19 цар тахалтай холбоотойгоор тус төв нь цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэхэд байгууллагын тасралтгүй үйл ажиллагааг хангаж ажилласан байна.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл болох гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан, худалдан авах ажиллагааны тайлан нь санхүүгийн бус мэдээллийг агуулсан тул санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

Хөвсгөл аймгийн Хатгал тосгоны Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлангийн гол нөлөө бүхий асуудал нь: Ковид-1 цар тахалтай холбоотойгоор 1.5 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн нөөц үүсгэсэн байна. Мөн 0.5 сая төгрөгийн томилолтын зардал хэмнэсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон 2.9 сая төгрөгийн нэмэлт орлогыг бүрдүүлж ажилласан байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан.

Байгууллагын 2021 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийг авч үзэхэд [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээлбэл зохих 1,286.6 сая төгрөгийн /давхардсан тоогоор/ 173 мэдээллээс 1,286.6 сая төгрөгийн 170 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна. Хугацаа болоогүй 3 мэдээлэл байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлтэй нийцсэн байна гэж дүгнэлээ.

Тус байгууллагын худалдан авах ажиллагааны баримт материалыг хянаж үзэхэд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй болно. Тайлант 154.5 сая төгрөгийн үнэ бүхий 16 удаагийн худалдан авах ажиллагаа зохион байгуулсан бөгөөд харьцуулалтын аргаар 10, шууд худалдан авах аргаар 6 арга хэмжээг зохион байгуулж ажилласан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчил, санал гомдол байхгүй байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөөгүй байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар бүртгэл тайлагналтай холбоотой 27.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 27.8 сая төгрөгийн алдааг залруулсан болно.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар 27.8 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн алдаа илэрснийг аудитын хугацаанд залруулсан болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Хөвсгөл аймгийн Хатгал тосгоны Эрүүл мэндийн төв	1	27.8	1	27.8						

/сая төгрөгөөр/